

**СУРГУУЛЬД СУУРИЛСАН ЭНТЕРПРАЙЗИЙН ТАНИЛЦУУЛГА PENCIL 2D ANIMATION БҮТЭЭХ СТУДИ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ УДИРДАМЖ**

Товч танилцуулга:

Хүүхдийг Ивээх Сан “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний үр чадвар, энтрепренершип боловсрол олгох төсөл”-ийг Ховд, Завхан, Өвөрхангай, Говьсүмбэр, Сүхбаатар аймгийн зорилтот 29 суманд Дэлхийн банкны итгэлцлийн сан болох Японы Нийгмийн Хөгжлийн Сангийн буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж байна.

Төслийн тогтвортой байдлыг хангаж Энтрепренершипийн боловсрол, үйл ажиллагааг орон нутагт түгээн дэлгэрүүлэх, сургуулийн менежментийн хөгжлийг дэмжих үүднээс төслийн зорилтот 5 аймагт 6 ерөнхий боловсролын сургуулийг Сургуульд Суурилсан Энтерпрайз (ССЭ) хэрэгжүүлэгчээр сонгон шалгаруулж 2022 оноос туршин амжилттай хэрэгжүүлж байна.

Сургуульд Суурилсан Энтерпрайз (ССЭ) гэдэг нь сурагчид сургуулийн орчинд зорилтот зах зээлийн эрэлт хэрэгцээг хангах бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх энтерпренерийн үйл ажиллагаа явуулахыг хэлнэ. ССЭ-ыг бий болгож хөгжүүлэх үндсэн зорилго нь сурагчид, өсвөр үеийнхний энтрепренер сэтгэлгээ, бүтээлч байдлыг хөгжүүлэх, улмаар хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай хувь хүний үр чадвар эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэхэд оршино.

Ерөнхий Боловсролын Сургууль (ЕБС)-ийн удирдлага, зохион байгуулалтын бүтцээр дамжуулж, ССЭ-ыг хэрэгжүүлж ССЭ-ыг сургуулийн захирал хариуцаж, удирдан зохион байгуулах ба сургуулийн багш, ажилтнууд, сурагчид өөр өөрийн үндсэн чиг үүргийн дагуу оролцдог.

Гэрээт ажлын зорилго: Гэрээт ажлын хүрээнд Сургуульд Суурилсан Энтерпрайз (ССЭ)-ын танилцуулга хийж зорилго, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд таниулах Pencil 2D animation төрлийн **видео бүтээл** хийж гүйцэтгэнэ.

Видео бүтээлд тавигдах нийтлэг шаардлага:

- Pencil2D animation төрлөөр бүтээх,
- Видео бүтээлийн хугацаа 3 минутаас ихгүй байна;
- Зохиолыг батлуулсны дараа анимейшнээ бэлтгэх ажлаа эхэлнэ.
- Видео зохиол, өгүүлэмж нь шинэлэг, сонирхолтой, бүтээлч байна.
- Өмнө нь бүтээсэн төслийн болон сургалтын танилцуулга видеотой үялдсан байна.
- Бүтээлийн агуулгыг дэмжих сонирхолтой график, схем зураглал, тоо баримт ашиглах;
- Видеоны зохиомж, найруулга, график, зураг, эвлүүлгийг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэсэн байх;
- Текстийг англи болон монгол хадмал байдлаар видеонд оруулна.
- Монгол хадмалтай видео нь дохионы хэлний орчуулгатай байх;
- Хүүхдийг Ивээх Сангийн брэндингийн дагуу гүйцэтгэнэ.
- Текстийг мэргэжлийн диктор уншсан байна.
- Зохиогчийн эрх, бусдын оюуны өмчийн эрхийн зөрчилгүй байна.

- Видеоог MP4 форматаар хүлээлгэж өгнө.

Ажил гүйцэтгэх хугацаа:

Тус ажлыг 2025 оны 2 дугаар сарын 06 -ны өдрөөс 2025 оны 3 дугаар сарын 13 -ны дотор дараах хуваарийн дагуу ажил гүйцэтгэнэ. Видеоог 2025 оны 3 дугаар сарын 14-нд хүлээж авна.

№	Гүйцэтгэх ажил	Дуусах хугацаа
1	Ажил гүйцэтгэх гэрээ байгуулах	2025 оны 2 сарын 07
2	<ul style="list-style-type: none"> • Төслийн болон зохиолын агуулга, үзэл санаатай танилцах • Бүтээл бэлэн болох хугацааг тохирох 	2025 оны 2 сарын 11
3	Захиалгат ажлыг гүйцэтгэх нарийвчилсан төлөвлөгөө хүлээлгэн өгөх	2025 оны 2 сарын 14
4	Бүтээлийн зохиолыг эцэслэх, санал солилцох, захиалагч талаас зөвшөөрөл авах	2025 оны 2 сарын 20
5	Бүтээлийн эхний хувилбарыг илгээж санал солилцох	2025 оны 3 сарын 10
6	Видео бүтээлийг эцэслэн төслийн багт хүлээлгэн өгөх	2025 оны 3 сарын 13

Гүйцэтгэгчид тавигдах шаардлага:

- Видео контент бүтээх салбарт багадаа 3 жил ажилласан туршлагатай байх,
- Телевизийн нэвтрүүлэг, анимейшн, баримтат кино бүтээх, зураг авалт, найруулгыг өндөр түвшинд хийх мэргэжлийн боловсон хүчин, бие даасан өөрийн эзэмшлийн студитэй байх,
- Телевизийн нэвтрүүлэг, баримтат кино бүтээх сүүлийн үеийн үзүүлэлт бүхий мэргэжлийн тоног төхөөрөмжтэй байх,
- Шинэлэг, бүтээлчээр хандах чадвартай уран бүтээлчдийн багтай байх.

Ирүүлэх материалууд:

- Ажлыг хийж гүйцэтгэх ажлын санал
- Үнийн санал, төсвийн задаргаа
- Ажлыг хийж гүйцэтгэх сонирхлоо илэрхийлсэн албан бичиг, байгууллагын гэрчилгээ
- Өмнө хийж байсан ижил төрлийн бүтээлүүдийн жагсаалт, линк
- 2024 оны санхүүгийн тайлан

Дээрх материалуудыг бэлтгэж, 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 17.00 цагаас өмнө mongolia.procurement@savethechildren.org ирүүлнэ үү.